Санхүүгийн мэдээллийн алба

2026



Худалдаанд суурилсан мөнгө угаах гэмт хэрэг

Гарын авлага

Агуулга

Удиртгал 3

Нэгдүгээр бүлэг. Худалдаанд суурилсан мөнгө угаах гэмт хэргийн ойлголт

- Мөнгө угаах гэмт хэрэг 5
- Худалдаанд суурилсан мөнгө угаах 5
- Худалдаанд суурилсан терроризмыг санхүүжүүлэх 6
- Худалдаанд суурилсан мөнгө угаах процесс 6
- Санхүүжилтийн аргууд 6

Хоёрдугаар бүлэг. Худалдаанд суурилсан мөнгө угаах гэмт хэргийн эрсдэл, цаашдын чиг хандлага

- Эрсдэл ба чиг хандлага 9
- ХСМУ ба эрсдэлд суурилсан аргачлал 10
- ХСМУ-д өртөмтгий бараа бүтээгдэхүүн 12
- ХСМУ-д өртөмтгий бизнесийн салбар 14
- ХСМУ нийтлэг аргууд 15
- ХСМУ эрсдэлийн үнэлгээ 16
- Үйлчилгээнд суурилсан мөнгө угаах 17
- Хориг арга хэмжээтэй холбоотой эрсдэл 17

Гуравдугаар бүлэг. Худалдаанд суурилсан мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлийн шинж тэмдэг

- Байгууллагын бүтэцтэй холбоотой шинж тэмдэг 21
- Худалдааны үйл ажиллагаатай холбоотой шинж тэмдэг 22
- Худалдааны баримт бичиг, бараатай холбоотой шинж тэмдэг 22
- Данс болон гүйлгээтэй холбоотой шинж тэмдэг 23
- Хориг арга хэмжээтэй холбоотой шинж тэмдэг 23

Дөрөвдүгээр бүлэг. Худалдаанд суурилсан мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгарч буй сорилтууд

- Мэдлэг, ойлголтын дутагдалтай байдал 25
- Дотоод хамтын ажиллагаа болон уялдаа холбоо 26
- Олон улсын хамтын ажиллагаа 26
- Мөрдөн шалгах болон шүүх ажиллагаа 27
- Хувийн хэвшлийн байгууллагуудад тулгарч буй сорилт 27

Тавдугаар бүлэг. Худалдаанд суурилсан мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх сайн туршлага, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

- ХСМУ гэмт хэргийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх 30
- СМА-ны цуглуулах санхүүгийн мэдээлэл 31
- СМА-аас ХСМУ гэмт хэргийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх 32
- ХСМУ-тай тэмцэхэд гаалийн байгууллагын үүрэг оролцоо 33
- Зохицуулагч байгууллагуудын хамтын ажиллагаа 34
- Төр, хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ) 35

Удиртгал

Худалдаанд суурилсан мөнгө угаах (цаашид “ХСМУ’ гэх) үйл ажиллагаа нь мөнгө угаах түгээмэл аргуудын нэг билээ. Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (цаашид “ФАТФ” гэх)-ын 2006 оны тайланд анх ХСМУ гэмт хэргийг өргөн хүрээнд үнэлж, гол арга техникүүдийг нь тодорхойлсон байдаг. Үүний дараагаар ФАТФ нь 2008 онд ХСМУ-тай холбоотой эрсдэлийг хянахын тулд улс орнуудын сайн туршлагуудыг багтаасан баримт бичгийг гаргасан. ХСМУ гэмт хэрэг нь олон улсын худалдааны хурд, олон талын үйл ажиллагаа болон санхүүжилттэй нягт уялдаатай байдаг тул түүнийг илрүүлэх, мөрдөн шалгах, таслан зогсооход хүндрэлтэй байдаг.

Монгол Улс нь газар зүйн байрлалаар томоохон хөрш улсуудтай хиллэдэг, гадаад худалдааны харилцаа нээлттэй тул ХСМУ гэмт хэргийн эмзэг сул байдлыг ойлгож, үүнээс урьдчилан сэргийлж, таслан зогсоох шаардлагатай. Энэ хүрээнд Монгол Улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (цаашид “МУТСТ” гэх) бодлого, олон улсад хүлээсэн үүргийн хүрээнд ХСМУ эрсдэлийг ойлгох, холбогдох арга хэмжээг авч ажиллах нь нэн чухал. Иймд Санхүүгийн мэдээллийн албанаас оролцогч талуудад зориулан энэхүү гарын авлагыг орчуулан, нэгтгэн, боловсруулаа.

Уг гарын авлага нь ХСМУ тухай ойлголт, хэв шинж, чиг хандлага, эрсдэлийн шинж тэмдэг, ХСМУ-тай тэмцэхэд тулгамдаж буй сорилт, ХСМУ-тай тэмцэх сайн туршлагууд гэсэн 5 хэсгээс бүрдсэн болно. Гарын авлагыг мэдээлэх үүрэгтэй этгээд болон бусад оролцогч талуудад зориулан боловсруулав. Мөн олон улсын худалдааны нарийн цогц байдлын талаар ойлголт өгөх, эрсдэлийг бууруулах арга замыг тодорхойлох, олон улсын санхүүгийн оролцогч талуудыг эрсдэлд өртөхөөс сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг тайлбарлахыг оролдлоо.

Аргачлал: ФАТФ-ын 2020 оны “*Худалдаанд суурилсан мөнгө угаах: цаашдын чиг хандлага ба хөгжил*” гарын авлага, 2021 оны “*Худалдаанд суурилсан мөнгө угаах: Эрсдэлийн шинж тэмдэг*” гарын авлагууд болон нэмэлт нээлттэй эх сурвалжийг ашиглан бэлтгэсэн болно.



Нэгдүгээр бүлэг

Худалдаанд суурилсан мөнгө угаах ойлголт

Худалдаанд суурилсан мөнгө угаах ойлголт

Худалдаанд суурилсан мөнгө угаах арга нь мөнгө угаах гэмт хэргийг үйлдэх аргуудын нэг төрөл юм. Энэ аргын хувьд дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн нэгдмэл тодорхойлолт байдаггүй. Иймд мөнгө угаах гэмт хэргийн тодорхойлолтоор худалдаанд суурилсан мөнгө угаахын ойлголт хэсгийг эхлүүлье.

Мөнгө угаах гэмт хэрэг

Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт "мөнгө угаах" гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдлахыг хэлнэ.

Үүнээс харвал мөнгө угаах нь дараах шинжийг агуулдаг:

1. Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсэн байх;
2. Дараах үйлдлийн аль нэгийг үйлдсэн:
   - авсан, эзэмшсэн, ашигласан;
   - түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн;
   - түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан.

Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлого гэдэгт гадаад улсад бол тухайн улсын хуулиар нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдэж шууд, шууд бусаар олсон эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг, орлого, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан техник, хэрэгслийг хамааруулахаар хуульчилжээ.

Худалдаанд суурилсан мөнгө угаах гэмт хэрэг

Худалдаанд суурилж мөнгө угаах гэдэг нь гэмт хэргээс олсон орлогыг нуун далдлах, хууль бус мөнгөний гарал үүсэл болон үйл ажиллагааг хууль ёсны болгох зорилгоор худалдаагаар халхавчлан шилжүүлэх үйл явцыг хэлнэ.


Худалдаанд суурилсан мөнгө угаах гэмт хэрэг	Худалдаатай холбогдох бусад гэмт хэрэг
Зорилго: Худалдааг ашиглан бараагаар халхавчлан гэмт хэргийн орлогыг шилжүүлэх **Оролцогч:** мэргэжлийн мөнгө угаагч (PMLs) оролцуулдаг буюу гэмт хэргийн захиалагч, үйлдэгч нь тусдаа байдаг.	**Зорилго:** Хууль бусаар бараа бүтээгдэхүүн худалдаалах зэрэг бараа бүтээгдэхүүнд чиглэсэн **Оролцогч:** хууль бус үйл ажиллагааны эцсийн өмчлөгч. гэмт хэргийг үйлдэгч нь гэмт хэргийг захиалагч байж болно.

Худалдаанд суурилсан терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг

Худалдаанд суурилж мөнгө угаахаас гадна терроризмыг санхүүжүүлэх эрсдэл бий. Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсэгт "терроризмыг санхүүжүүлэх гэж террорист этгээд, террорист үйлдэл, үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд болон шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, өөрчилсөн, шилжүүлсэн, зарцуулсныг" хэмээн тодорхойлсон байдаг ба үүнээс тусдаа худалдаанд суурилсан терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг тодорхойлоогүй байна.

ФАТФ-ын тодорхойлолт ёсоор худалдаанд суурилсан терроризмыг санхүүжүүлэх (цаашид "ХСТС" гэх) гэдэгт ***хууль ёсны болон хууль бус орлогоор*** терроризмыг санхүүжүүлэх зорилго бүхий шилжүүлгийг худалдаагаар дамжуулан нуун далдлахыг хэлнэ.

Худалдаанд суурилсан мөнгө угаах процесс



Санхүүжилтийн аргууд

Олон улсын худалдааны төлбөр тооцоо болон бараа бүтээгдэхүүний хүргэлтийн хугацааны ялгаанаас үүдэн экспортлогч, импортлогчид эрсдэлтэй нөхцөл байдал үүсгэдэг. Энэ бэрхшээлийг даван туулах үүднээс олон улсын зах зээлийг дэмжих санхүүгийн үйлчилгээ хөгжсөн байдаг. Хүснэгт 1-д үндсэн 5 арга, тэдгээрийг экспорт импортлогчийн хувьд эрсдэлтэй байдлаар жагсаасныг харж болно.


Хүснэгт 1. Санхүүжилтийн аргууд

	Хамгийн бага	Бага	Дунд	Их	Хамгийн их
Экспортлогч	Консигнац	Нээлттэй төлбөрийн нөхцөл	Баримтын инкассо	Аккредитив	Урьдчилсан төлбөр
Импортлогч	Урьдчилсан төлбөр	Аккредитив	Баримтын инкассо	Нээлттэй төлбөрийн нөхцөл	Консигнац

Санхүүжилтийн аргуудын тайлбар


Нээлттэй төлбөрийн нөхцөл

Энэхүү арга нь бараа хүргэлт, төлбөр төлөлтийн хугацаа нь харьцангуй урт байдаг тул бараан дээрх хяналт сулардаг бөгөөд ХСМУ үйл ажиллагаанд ихэвчлэн энэ аргыг ашигладаг. ФАТФ-ын гарын авлагад дурдсанаар олон улсын худалдааны гүйлгээний 80% нь уг аргаар хийдэг байна.




Баримтын инкассо

Баримтын инкассо нь экспортлогчийн санхүүгийн байгууллага барааны баримт бичгийг импортлогчийн санхүүгийн байгууллагад илгээж төлбөр болон хүргэлтийг баталгаажуулдаг арга. Баримт бичигт хуурамч үнэ, тоо хэмжээг оруулах, эсвэл 1 барааны хэд хэдэн удаа төлбөр төлөх зэргээр мөнгө угаахад ашиглагдах эрсдэлтэй.




Аккредитив

Худалдан авагчийн банк экспортлогчид төлбөрийг гүйцэтгэхийг баталгаажуулдаг бөгөөд экспортлогч шаардлагатай баримтуудыг хангаж өгсний дараа л төлбөр хийдэг. Аккредитивын дор хуурамч баримт бичиг үйлдэн, 1 тээвэрт хэд хэдэн аккредитив хийх зэргээр мөнгө угаахад ашиглагдах эрсдэлтэй.




Консигнац

Консигнацийн худалдаанд бараа бүтээгдэхүүнийг экспортлогч гуравдагч тал эсвэл агуулахад хүлээлгэн өгч, тухайн бараа зарагдсан үед л экспортлогч төлбөрөө хүлээн авдаг. Энэ хугацаанд гэмт хэрэгтнүүд үнийн хуурмаг байдлыг бий болгох, үнэ цэнийг өөрчлөх байдлаар ХСМУ гэмт хэрэг үйлдэх эрсдэлтэй.



Урьдчилсан төлбөр

Урьдчилсан төлбөрийн аргаар худалдан авагч бараа бүтээгдэхүүнийг авахын өмнө төлбөрийг бүрэн төлдөг. Үүгээр хэзээ ч илгээхгүй бараанд төлбөр төлөх, илүү төлөх зэргээр гэмт хэрэг үйлддэг.





Хоёрдугаар бүлэг

Худалдаанд суурилсан мөнгө угаах эрсдэл, цаашдын чиг хандлага

Эрсдэл ба чиг хандлага

ФАТФ-ын зөвлөмж 1-д улс орон өөрийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх, түүнд тулгуурласан арга хэмжээ авахыг заасан байдаг. Энэ бүлэгт ХСМУ гэмт хэрэгт өртөх эрсдэлд илүү анхаарахын зэрэгцээ улс орнууд ХСМУ/ТС-д өртөх эрсдэлээ тоон дүнгээр тодорхойлоход хүндрэлтэй байдгийг мөн харгалзан үзсэн болно. Энэхүү хэсгээс дараах ойлголтуудыг авах болно.

01

Эрсдэлд суурилсан аргачлал

ФАТФ-аас гаргасан зөвлөмжийн шаардлагуудтай танилцах, дотоодын хууль, эрх зүй, бодлого чиглэлийн хүрээнд хэрхэн ХСМУ/ТС-тэй тэмцэх талаар ойлголттой болох. Улс орнууд хэрхэн эрсдэлээ таньж мэдсэнээр хууль бус үйл ажиллагаанаас сэргийлж болох талаар судлахад чиглэнэ.

02

Эрсдэлтэй салбар, бараа бүтээгдэхүүн, бизнесийн салбар

ХСМУТС- гэмт хэрэгт өртөмтгий эдийн засгийн салбар бараа бүтээгдэхүүнтэй танилцаж, гэмт хэрэгтнүүд хэр өргөн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг, түүнийг хэрхэн таньж мэдэх талаар суралцахад чиглэнэ.

03

Суурь гэмт хэргүүд

ХСМУТС гэмт хэргийн нийтлэг суурь гэмт хэргүүдийг тодорхойлох буюу эрх бүхий байгууллага тухайн суурь гэмт хэргийн талаар тусгасан.

04

ХСМУ арга техник

ХСМУ арга техникүүд, жишээтэй танилцах.

ХСМУ ба эрсдэлд суурилсан аргачлал

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг /цаашид “АНДМУТБ” гэх/-ийн 2012 оны тайлангаас хойш ФАТФ-ын зөвлөмжүүд болон МУТСТ арга хэмжээнүүдийн үнэлгээний журамд томоохон өөрчлөлтүүд орсон. ФАТФ-ын харилцан үнэлгээ хийх аргачлалаар ФАТФ-ын зөвлөмжийг зөвхөн хууль тогтоомжид суулгах бус, харин МУТСТ арга хэмжээнүүдийг бодит практикт хэрэгжүүлэх тал дээр анхааран үзэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл МУТСТ хууль, эрх зүйн орчинтой байх нөхцөл дээр нэмээд уг эрх зүйн орчны хэрэгжилтийг үнэлэх шаардлагатай. Энэхүү аргачлалын нэг хэсэг нь эрсдэлд суурилсан аргачлал юм.

ФАТФ-ийн Зөвлөмж 1-д улс орнууд МУТС-д өртөх эрсдэлээ тодорхойлох, үнэлэх, ойлгох болон тэдгээрт тохирсон урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай гэж заасан байдаг. Энэ зөвлөмжийг биелүүлэхийн тулд улс орнууд Үндэсний Эрсдэлийн Үнэлгээ (цаашид “ҮЭҮ” гэх) хийх шаардлагатай байдаг.

Нийтлэг суурь гэмт хэрэг

ХСМУ болон ХСТС нь дотоодод үйлдэгдэж байгаа болон үндэстэн дамнасан гэмт хэргүүдтэй холбогдож байдаг. Хар тамхи наймаалах, зэвсэг худалдаалах гэх суурь мөнгө угаах гэмт хэргээс гадна татвараас зайлсхийх зэрэг бараа бүтээгдэхүүн агуулаагүй ХСМУ схемүүд өргөн дэлгэрч байна.

Эдгээр арга хэлбэр нь нийлүүлэлтийн шинэ сүлжээ үүсгэж, олон улсуудыг хамарснаар гэмт хэргийн орлогын уг гарал үүслийг нуун далдалж, мөрдөн шалгах үйл ажиллагааг нарийн төвөгтэй болгодог. Гэмт хэрэгтнүүд боломжит арга зам, хийдлийг ашигладаг энэ байдалтай тэмцэхэд ҮЭҮ нь тусалдаг (Жишээ 1). Олон улсын худалдааны нарийн төвөгтэй байдал нь ямар ч төрлийн суурь гэмт хэргийг үйлдэн мөнгө угаах боломжийг нэмэгдүүлдэг байна. Иймд ХСМУ-сан суурь гэмт хэргийг жагсаан гаргахад төвөгтэй байдаг ч аль суурь гэмт хэрэг илүү үйлдэгдэж буйг тогтооход эрсдэлийн үнэлгээ тусалдаг.

Жишээ 1

Герман улсын ҮЭҮ

Герман улсад 2017 онд Холбоодын Сангийн яамны удирдлага доор 35 холбооны болон орон нутгийн эрх бүхий байгууллагууд оролцон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх ҮЭҮ-г хийжээ.

Эхний ҮЭҮ-нд ХСМУ-ын дутуу эсвэл хэтрүүлж нэхэмжлэх, давхардуулан төлбөр төлөх, хуурамчаар худалдах, халхавч компани ашиглах, үнэтэй бараа бүтээгдэхүүн бэлэн мөнгөөр худалдан авах зэрэг аргуудыг илрүүлжээ. Уг эрсдэлийг тодорхойлоход мэдээлэх үүрэгтэй этгээдийн мэдээлэл, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа чухал нөлөөтэй байв.

Энэ туршлагаас үүдэн санхүүгийн байгууллага тэр дундаа банкны салбар ХСМУ гэмт хэргийн шинж тэмдгийг илүүтэй таньж мэдэж СМА-д сэжигтэй гүйлгээний тайлан илгээхэд дөхөм болсон.

Эрсдэлийн үнэлгээ

Ихэнх улс орон санхүү болон худалдааны систем, хуулийн этгээд зэргийг ХСМУ-д ашиглах эрсдэлийг өөрсдийн ҮЭҮ-д тусгасан байдаг (Жишээ 2). ХСМУ-ыг эрсдэлтэй гэж үзээгүй, ҮЭҮ-д тусгаагүй цөөхөн улс орон байсан ч тэдний зарим нь хуулийн этгээд хуурамчаар үүсгэх гэмт хэргийг эдийн засгийн гэмт хэрэгт хамааруулан тусгасан байна. Мөн зарим хуулийн этгээд ХСМУ-д өртөх эрсдэлээ хүлээн зөвшөөрч, дотооддоо эрсдэлийн үнэлгээ хийдэг байна (Жишээ 3).

ФАТФ-ын зөвлөмжийн дагуу эрсдэлд өртөмтгий байдлыг зөв тодорхойлсноор шаардлагатай арга хэмжээг авч, үр дүнтэй хамтын ажиллагаа хэрэгжүүлэх боломжтой болно гэж үздэг. Энэ хүрээнд нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага зэрэг мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд (Жишээ 4) ч мөн адил ХСМУ/ТС гэмт хэрэгт өртөх эрсдэлээ харгалзан үзэх шаардлагатай.

Жишээ 3

Хувийн байгууллагаас дотооддоо хийдэг эрсдэлийн үнэлгээ

Сингапур улсын ҮЭҮ-ээр ХСМУ-ыг тэргүүлэх ач холбогдол бүхий эрсдэлтэй салбар хэмээн тодорхойлсон байдаг. Энэ хүрээнд нэг санхүүгийн байгууллага дээр газар зүйн байршил, бүтээгдэхүүн, үйлчилгээ, гүйлгээний эрсдэлийг үнэлсэн бөгөөд эрсдэлтэй хэмээн үр дүн гарсан байна.



Цаашид ХСМУ гэмт хэргийг илрүүлэх, бусад эрсдэлээс сэргийлэх үүднээс байгууллагын зүгээс гүйлгээний автомат хяналтын систем ашиглахаар төлөвлөжээ. Энэ нь өгөгдөл, сүлжээг ашиглан эрсдэлтэй хэрэглэгчийг шалгаж, хувийн гүйлгээг гар аргаар шалгадаг аргыг халсан байна.

Жишээ 2

АНУ-ын ҮЭҮ болон ХСМУ

АНУ-аас ХСМУ-ыг улс оронд аюул заналхийлэл учруулах эрсдэлтэй талбар гэж үздэг. Тэр дундаа Мексик болон Европын үндэстэн дамнасан гэмт хэргийн бүлэглэл ХСМУ аргаар хар тамхи наймаалах гэмт хэрэг үйлдэж байгааг эрх бүхий байгууллагаас илрүүлэхэд төвөгтэй болгож байна гэж үздэг. Нөгөө талаас санхүү болон худалдааны салбар нь өөрөө ХСМУ эрсдэл өндөртэй салбар юм.

АНУ-д ХСМУ-ыг 2005 оноос ҮЭҮ-д хамааруулсан. 2015 оны Үндэсний Мөнгө угаах эрсдэлийн үнэлгээнд ХСМУ нь ихэвчлэн нууц худалдагч, халхавч компаниар дамжуулан бараа бүтээгдэхүүнийг хууль бус хөрөнгөөр сольж буйг тусгажээ. Үүний дараагаар АНУ-ын Сангийн яамнаас зарим нэг санхүүгийн байгууллагатай энэхүү дүгнэлтийн талаар хэлэлцүүлэг өрнүүлсэн байна.

2018 онд анхны Хууль бус санхүүгийн эсрэг стратегийг боловсруулж, ҮЭҮ-г шинэчилсэн. 2018 оны тайлангаар ХСМУ арга нь ашиглагдсаар байгаа бөгөөд үүнд мөнгө угаах мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийг ашиглах болсныг дурджээ.


Ингээд 2020 оны Хууль бус санхүүгийн эсрэг стратегиар үндэстэн дамнасан гэмт хэргийн бүлэглэл Азийн мөнгө угаах үйлчилгээ үзүүлэгчдийг ашиглаж байгааг дурдсан ба ХСМУ нь АНУ-ын хилээр их хэмжээний бэлэн мөнгө нэвтрүүлсэн гэмт хэрэг багасах шалгаан болсон байх магадлалтайг тодотгожээ.

Жишээ 4

Үнэт метал худалдаалах нөхцөлийг чангатгасан нь

Германы ҮЭҮ-ний дүгнэлт болон санхүү шинжээчдийн хяналтаар Германд үнэт эдлэлийн худалдаа МУ-д өртөмтгий байгааг тогтоосон. Үүнд тухай үеийн хууль эрх зүйн зохицуулалт болох зөвхөн 10'000 еврогоос дээш үнийн дүнтэй үнэт эдлэл худалдахад хэрэглэгчид нарийвчилсан шалгалт хийх байдал нь 10'000 евро хүртэлх бохир бэлэн мөнгөөр үнэт эдлэл худалдах боломжийг олгож байгааг онцолжээ.

Иймд Герман улс Европын холбооны Мөнгө угаахтай тэмцэх 4 дэх чиглэлийн дагуу үнэт эдлэл, чулууны худалдан авагчид хянан шалгалт хийх үнийн дүнг 2'000 евро болгон буулгажээ. Өөрөөр хэлбэл 2'000 еврогоос дээш үнэтэй бол хяналт шалгалт хийгдэх эрх зүйн орчин бүрджээ.





ХСМУ-д өртөмтгий бараа бүтээгдэхүүн

Гэмт хэрэгтнүүд улс дамнасан харилцагчаа таньж мэдэх болон хянан шалгалтын зохицуулалт ялгаатайгаас, эсвэл эдгээр нь зохицуулагдаагүй байдлыг ашиглан гэмт хэргээс олсон мөнгийг угаадаг. Мөн ХСМУ аргад их болон бага үнийн дүнтэй барааны алийг нь ч ашиглах боломжтой байдаг. Бага дүнтэй барааны хувьд олон улсаар дамжуулахад хялбар, бага анхаарал татдаг тул гэмт хэрэгтнүүдэд ашиглагдах эрсдэл харьцангуй өндөр байдаг. Өндөр дүнтэй барааны хувьд санхүүгийн хүндрэлтэй байгаа бизнесүүдийг мөнгө угаах хэрэгсэл болгон ашигладаг. Мөн дараах бараа бүтээгдэхүүн ХСМУ-д өргөн ашигладаг. Үүнд:

- Үнийн ялгаатай байдал ихтэй бараа;
- Хэд хэдэн үе дамжлага дамждаг бараа;
- Гаалийн хянан шалгагч шалгахад төвөгтэй бараа.

Доор зарим нэг өртөмтгий бараа бүтээгдэхүүнийг дэлгэрэнгүй тайлбарласан болно.

Алт, үнэт металл, үнэт чулуу

Гэмт хэргээс олсон орлогыг алт, үнэт металл, чулуу зэргээр орлуулах нэг этгээдээс нөгөө этгээдэд шилжүүлэх боломжтой.

Авто тээврийн хэрэгсэл, сэлбэг

Гэмт бүлэглэлээс авто хэрэгслийн сэлбэг, машины тээвэрлэлтийн үед үнийг бууруулах, эсвэл төлбөрийг өөр улсын олон төрлийн сувгаар төлөх боломжтой байдаг.

Жишээ 5

Алтыг ХСМУ-ын хэрэгсэл болгон ашиглах нь

АНУ-д Перу Улсын иргэдийг алт ашиглан мөнгө угаасан гэмт хэргээр яллаж байжээ. 2013-2017 оны хооронд тэдгээр хүмүүс хууль бус олборлолт, гадаадын хээл хахууль, хууль бусаар хил давуулах зэрэг гэмт хэргийн үйл ажиллагаанаас олсон орлого гэдгийг мэдэж байсан ч Латин Америк, Карибын тэнгисийн орнуудаас гэмт хэргийн шинжтэй олон тэрбум долларын алт худалдан авахаар хуйвалдсан байна.

Тэд Флорида хотод байгуулагдсан үнэт металлын үйл ажиллагаа эрхэлдэг компанийг ашиглажээ. Ингээд АНУ-д алт цэвэршүүлэх нэрийдлээр тухайн алтыг зарж гэмт хэрэг үйлдсэн байна.

Жишээ 6

Тээврийн хэрэгслийг ХСМУ-ын арга хэрэгсэл болгон ашиглах нь

Испани болон Итали улсын эрх бүхий байгууллагуудын хамтарсан мөрдөн шалгах үйл ажиллагааны үр дүнд хар тамхи, авлигын гэмт хэргийн орлогыг угааж буй үйлдлийг илрүүлжээ. Гэмт бүлэглэл дараах байдлаар үйл ажиллагаа явуулжээ. Үүнд:

1. Герман улсаас үнэтэй машин худалдан авсан;
2. Машиныг буцааж худалдахаар халхавч компани байгуулсан;
3. Хуурамч бичиг баримт үйлдэн орлогын эх үүсвэрийг нуусан;
4. Гэмт бүлэглэл Итали улсын нийлүүлэгчээс жил бүр их хэмжээний машин оруулж ирэхийг ятгасан;
5. Үнэтэй машинаас гадна үнэтэй дээд зэрэглэлийн цаг, хямдхан бараа бүтээгдэхүүнийг мөн худалдан авч борлуулах байдлаар үйл ажиллагаагаа олон чиглэлд явуулсан;
6. Төлбөрийг олон улсаар дамжуулан хийсэн.

2017-2018 онд хуулийн байгууллагууд уг үйлдлийг олж илрүүлэн 8 сая евро хүрэх хөрөнгө, данс, машиныг хураан авсан байна.

ХАА-н бүтээгдэхүүн, хүнс

Хурдан мууддаг бүтээгдэхүүн, хүнсний бараа нь хямд бөгөөд хяналт шалгалтыг хурдан шуурхай хийх шаардлагатай байдаг нь мөнгө угаахад ашиглах арга хэрэгслийн нэг болгодог.

Электрон бараа бүтээгдэхүүн

Электрон барааг үнийг нь буруу тодорхойлох, үнэтэй барааг хямд барааны нэрээр нэрлэх зэргээр мөнгө угаах хэрэгслээ болгодог. Жишээ 8-аас электрон барааг хэрхэн ашиглаж байгаатай танилцана уу.

Жишээ 7

ХАА-н бүтээгдэхүүн, хүнсийг ХСМУ гэмт хэргийн хэрэгсэл болгон ашиглав

Автомашинд хийсэн нэгжлэгээр 300'000 евро илэрсэнтэй холбогдуулан Франц, Бельги, Нидерланд улсууд 2016 онд хар тамхины наймаатай холбоотой мөнгө угаах гэмт хэрэгт хамтарсан мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

Мөрдөн шалгалтын үеэр гэмт бүлэглэл нь мэргэжлийн мөнгө угаах үйлчилгээ үзүүлэгчдийг хөлсөлсөн ба тэд Франц, Бельги улс дахь нуугдмал мөнгөн гуйвуулгын арга ашиглаж орлогыг цуглуулсан нь тогтоогджээ. Гэмт бүлэглэл төмс, сонгиныг Нидерланд болон Германаас их хэмжээгээр худалдан авч Африкийн хэд хэдэн компани руу экспортлох замаар хууль бус мөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулж иржээ.

Эдгээр Африкийн хүнс худалдан авагч компаниудаар төлбөрийг хар тамхины наймаачдын дансанд хийлгэж 2019 онд эдгээр хар тамхины наймаачдыг барьж 4,8 сая евро хөрөнгийг, 7 сая евро бэлэн мөнгийг хураан авчээ.

Жишээ 8

Өргөн хэрэглээний электрон барааг ХСМУ гэмт хэргийн хэрэгсэл болгон ашиглав

2017 онд Австралийн хилийн хяналтын байгууллагаас жижиг хэмжээний электрон бараатай холбоотой хянан шалгалт хийв. Ингэхдээ сэжигтэй гүйлгээний тайлан, банкны дэлгэрэнгүй мэдээллийн тусламжтайгаар 303.6 сая ам.долларын гүйлгээ Австралийн банкаар хийгдсэнийг илрүүлсэн.

Гэмт бүлэглэл Хойд Америкад хар тамхи хууль бусаар наймаалж, олсон орлогыг дараах маршрутаар дамжуулан мөнгө угааж байсан байна. Үүнд:

Хойд Америк-Зүүн өмнөд Ази-Австралийн санхүүгийн байгууллага-Оффшор данс/Өргөн хэрэглээний электрон бараа

Австралийн хилийн хүчин үүнд дүн шинжилгээ хийж, экспортын гаалийн мэдүүлгийг бусад орны импортын мэдээлэлтэй харьцуулж үзэхэд худал нэхэмжлэл үйлдсэн зөрчил илэрсэн байна. Ийнхүү цаашдын мөрдөн шалгах үйл ажиллагаагаар гэмт бүлэглэл электрон бараа ашиглан мөнгө угаах гэмт хэрэг хийж байсныг тогтоожээ.

Хувцас болон хуучин бараа бүтээгдэхүүн

Хоол хүнстэй адилаар хувцас, комиссын бараа бүтээгдэхүүн нь бага үнийн дүн бүхий өргөн хэрэглээний бараа бөгөөд үнэ тогтоох зааг хэтэрхий өргөн байдаг нь гэмт хэргийн хэрэгсэл болоход хүчтэй нөлөөлдөг.

Хэд хэдэн санхүүгийн байгууллагаас энэхүү салбарыг эрсдэлтэй гэж үзсэн ба зарим төр хувийн хэвшлийн түншлэлээс тус салбарын сэжигтэй шинж тэмдгүүдийг мэдээлэх зөвлөмж гаргасан байдаг.

ХСМУ-д өртөмтгий салбар

Эдийн засаг, бизнесийн олон төрлийн салбар ХСМУ-д өртөмтгий байж болно.

Анхааралдаа авах шинж тэмдгүүд:

- Зах зээлд олон тооны шинэ компани гэнэт орж ирэх
- Үл мэдэгдэх гуравдагч этгээдэд чиглэсэн тогтмол бэлэн мөнгөний төлбөр ажиглагдах
- Үндэслэлгүй нарийн төвөгтэй нийлүүлэлтийн сувгуудтай
- Өөрт ямар ч хамааралгүй салбарт гэнэт үйл ажиллагаа явуулж эхлэх
- Өөрийн бизнест хамааралгүй нэгээс олон салбарт үйл ажиллагаа хэд хэдэн удаа явуулах

Эдгээр шинж тэмдгээс нэгээс илүүг агуулсан байх нь тухайн компани зайлшгүй ХСМУ хэрэгсэл болсон гэсэн үг биш бөгөөд нарийн шалгалт хэрэгтэй болохыг харуулж буй хэрэг юм.

Халхавч компани

Халхавч болон фронт компаниуд нь мөнгө угаах гэмт хэрэгт нэлээдгүй ашиглагддаг. Халхавч компани ашиглах нь зарим тохиолдолд мөнгө угаах гэмт хэрэгтэй холбогдож болох ч бүх халхавч компани холбогддог гэсэн үг биш. ХСМУ гэмт хэрэгт идэвхтэй үйл ажиллагаатай нийлүүлэлтийн сүлжээг ашиглах тохиолдолд халхавч компани ашиглах шаардлага гардаггүй. Гэмт хэргийн бүлэглэл нь халхавч компанийг эцсийн өмчлөгчийг нуух зорилготойгоор ХСМУ схемийн нэг хэсэг болгох боломжтой. Харин фронт компанийн хувьд бизнест бэлэн мөнгө нийлүүлэх, банкан дахь дансаар нь хил дамнуулан мөнгө шилжүүлэхэд ашигладаг.

Тээвэр зуучлагч

Тээвэр зуучлагч нь бараг тээвэрлэх, гаалийн бүрдүүлэлт хийх, түүний эздрээтэй байдлыг зохицуулах үүрэг гүйцэтгэдэг. Тэд бараг хүргэх хамгийн үр ашигтай тээвэрлэлтийн замыг тодорхойлохдоо үр дүнтэй тул мөнгө угаах үйл ажиллагааны оролцогч болох эрсдэлтэй.

Тээвэр зуучлагч ХСМУ үйл ажиллагаа эрхэлж байж болзошгүй эрсдэлээс сэргийлж дараах баримт бичгийг шалгаж болно:

- Арилжааны нэхэмжлэх – тогтсон стандарт байхгүй ч үүнд гүйлгээний талууд, тээвэрлэж буй барааны тухай мэдээлэл, зохицуулалттай барааны ангиллын тайлбар, код тусгагдсан байдаг. Арилжааны нэхэмжлэх нь тухайн нэхэмжлэх нь үнэн болох тухай бичгийг мөн агуулж болно.
- Мэдүүлэг – Тээвэрлэгч эсвэл түүний төлөөлөгчөөс ачааг хүлээн авснаа баталгаажуулан олгодог баримт бичиг юм. Энэ баримт бичиг нь дараах гурван үндсэн үүрэгтэй:
    1. Ачаа ачигдсаныг баталгаажуулах.
    2. Тээврийн гэрээний нөхцөлийг агуулж, эсвэл нотлох баримт болох.
    3. Барааны өмчлөлийг илтгэх баримт бичиг болох.

Гаалийн брокер

Брокер нь импортлогчийн гаалийн бүрдүүлэх болон татвар төлөх, гаалийн тооцоо хийхэд тусалдаг. Ингэхдээ:

- Бараа бүтээгдэхүүний код зөв бичигдсэн эсэхэд анхаарах
- Гаалийн байгууллагатай харьцах
- Шаардлагатай тохиолдолд зөвшөөрлийн хувьд зөвлөгөө өгөх
- Татвар, гаалийн хураамжийг зөвөөр төлөхөд туслах гэсэн үйл ажиллагаа эрхэлдэг.

Ихэнх оронд гаалийн брокер, тээвэрлэгч нар мэдээлэх үүрэгтэй этгээдэд ордоггүй. Гэвч гаалийн брокер мөнгө угаах гэмт хэргээс сэргийлэх болон гэмт хэрэгт хамтран оролцохгүй байх нь ХСМУ гэмт хэргээс сэргийлэх нэг арга болдог.

Эдгээр гадаад худалдааны оролцогч талууд нь нэг талаасаа мөнгө угаахад ашиглагдаж болох ч нөгөө талаасаа мөнгө угаах эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой.

ХСМУ нийтлэг аргууд

Илүү болон дутуу нэхэмжлэл гаргах

Бараа үйлчилгээний үнийг гуйвуулж илэрхийлэх арга юм. Энэ тохиолдолд ихэвчлэн импортлогч, экспортлогч хоёулаа энэхүү үйл ажиллагаанд харилцан тохиролцож ордог.

Илүү болон дутуу тээвэрлэх

Бараа үйлчилгээний үнийг гуйвуулахтай адил төстэй ба барааны тоо хэмжээг гуйвуулах юм. Үүний нэг жишээ нь “phantom shipping” буюу бараа худалдах нэрийдлээр бараагүй онгоц явуулах юм.

Бараа, үйлчилгээний нэхэмжлэхийг олон дахин ашиглах

Уг аргад үнийн дүнг гуйвуулах шаардлагагүй харин бараа бүтээгдэхүүний баримт бичгийг олон дахин ашигладаг. Өөрөөр хэлбэл хяналт шалгалтаас хол байх үүднээс нэг барааны хууль ёсны бичиг баримтыг хил дамнуулан хэд хэдэн санхүүгийн байгууллагад хүргүүлж төлбөр хийх замаар гэмт хэргийн орлогыг шилжүүлдэг.

Бараа, үйлчилгээг хуурамчаар тодорхойлох


ХСМУ үйл ажиллагааны нэг арга нь бараа бүтээгдэхүүний шинж чанар, төрлийг буруу мэдээлэх замаар орлого шилжүүлэхийг хэлнэ. Өөрөөр хэлбэл бага үнэтэй барааг үнэтэй мэтээр мэдүүлэх, эсвэл өндөр үнэтэй барааг хямд бараа мэт мэдүүлэх гэх мэт.

Эдгээр аргуудыг мөнгө угаахад хослуулан хэрэглэх тохиолдол байдаг. Жишээлбэл, нэг нэхэмжлэх олон дахин ашиглах болон “phantom shipping”-ыг хамт ашиглаж болно. Эхний тээвэрлэлтээр бараа бүтээгдэхүүнийг үнэн зөв илгээж, хоёрдох шилжүүлэг дээр эхний нэхэмжлэхийг ашиглан хоосон тээвэрлэлт хийх гэх мэт. Үүний нэг ХСМУ-ын уламжлалт жишээ бол Хар захын Песо арилжаа юм.

Жишээ 9

Хар захын Песо арилжаа

2020 оны 1 сард АНУ-ын Хууль зүйн яамнаас Колумбын 6, Энэтхэгийн 1 иргэнийг олон улсын мөнгө угаах хэргээр ялласан. Black Market Peso Exchange (BMPE) нь АНУ-д хар тамхи зарж олсон бэлэн долларыг Колумбын песо руу хууль бус аргаар шилжүүлэх мөнгө угаах схем юм. Хар тамхины наймаачид АНУ-д борлуулсан мөнгөө Колумб дахь песо зуучлагчидтай холбогдож, зах зээлийн бус ханшаар солиулдаг. Зуучлагч эдгээр долларыг АНУ-д бараа экспортолж буй нийлүүлэгчид импортлогчдын өмнөөс төлж, гадаад худалдааны гүйлгээ мэт бүртгүүлэн хууль ёсны мэт болгож угаана. Харин импортын бараа Колумби улсад ирэхэд зуучлагч түүнийг борлуулж песо олж авснаар шинэ песотой болж, бүх процесс дахин давтагддаг.



ФАТФ болон СМА, хувийн байгууллагуудын олж мэдсэнээр эдгээр аргууд нь ашиглагдсаар байгаа ч орчин үед импортлогч экспортлогч нар харилцах шаардлагагүй эсвэл барааны хийгдэж буй гүйлгээний эх үүсвэрийг тодорхой болгох шаардлагагүй тохиолдолд гэмт хэргийн бүлэглэл хууль ёсны зах зээлд оролцож бохир мөнгийг хууль ёсны болгож байна.

ХСМУ эрсдэлийн үнэлгээ

ХСМУ аргуудыг мөнгөн гуйвуулга ашиглан мөнгө угаах аргуудтай хамт ашигладаг бөгөөд шинэ арга техникүүд ч хөгжсөөр байна. Эдгээр шинэ арга хэрэгсэл нь бараа бүтээгдэхүүний мэдээлэлтэй холбогдолгүй байдлаар мөнгө угаах нөхцөлийг бүрдүүлдэг. Иймд эдгээрийг эрсдэлийн үнэлгээнд тусгах нь зүйтэй.

Хууль бус бэлэн мөнгийг хууль ёсны эргэлтэд оруулах

Хууль бус бэлэн мөнгөний интеграцчилал гэдэг нь хууль бусаар олсон хөрөнгийг жинхэнэ гарал үүслийг нь нуун дарагдуулах замаар хууль ёсны санхүүгийн системд оруулахыг хэлнэ.

Санхүүгийн байгууллагуудыг ашиглах

Гэмт бүлэглэлээс мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд сэжиг төрүүлэхгүйн тул албан бус санхүүгийн байгууллага, “хавала”-г ашигладаг Үүнээс сэргийлэхийн тулд санхүүгийн байгууллагууд харилцагчийг таньж мэдэх зохицуулалтыг дагаж мөрдөх шаардлагатай.

Оффсет схем

Нөхөн төлөх, буцаан төлөх байдлаар мөнгө угаах техникийн нэг жишээ нь Хар захын Песо худалдаа юм. (Жишээ 9)

Орлуулах бараа худалдан авах арга

Энэ нь илүү орлоготой этгээд эсвэл гэмт хэрэгтний өмнөөс худалдан авалт хийдэг хувь хүн бүлэг этгээдийг багтаадаг.

Зуучлагчаар дамжуулан нэхэмжлэх зохицуулах

Худалдагч худалдан авагчийн хооронд гуравдагч этгээдээр зуучлуулах байдлаар мөнгө угаах арга техникийг хэлнэ. (Жишээ 11)

Жишээ 11

Гуравдагч этгээдээр дамжуулан мөнгө угаах

Шинэ Зеланд улсын Санхүүгийн мэдээллийн алба нь нэгэн жимс экспортлогч компанид зүүн Европ дахь данснаас ирж буй гүйлгээтэй холбоотой сэжигтэй гүйлгээний тайлан хүлээн авсан. Сэжигтэй гүйлгээний тайлангаас харвал компани 18 сарын турш 1.5 сая долларын гүйлгээ хийжээ. Цааш шалгахад энэ төлбөр нь экспортыг хүлээн авсан компани бус өөр халхавч компаниас орж иржээ.

Экспорттой холбоотой нэхэмжлэлийг харвал нэхэмжлэлд керамик плита гэж бичсэн байжээ. Нэхэмжлэхэд компанийн менежер зурсан гэсэн боловч, тийм нэртэй ажилтан уг компанид байдаггүй байжээ.

Санхүүгийн мэдээллийн албанаас уг төлбөр нь Зүүн европоос гарч буй ХСМУ схемийн нэг хэсэг бөгөөд бараг бохир мөнгөөр бараа худалдан авч, дараа нь буцааж заран цэвэр мөнгө болгодог болохыг олж тогтоожээ.


Хууль ёсны нийлүүлэлтийн сүлжээнд нэвтрэх

Мөнгө угаагчид хууль ёсоор байгуулагдсан санхүүгийн асуудалтай байгаа бизнесүүдийг ашиглан нийлүүлэлтийн сүлжээнд нэвтэрдэг. Энд гэмт бүлэглэл тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг сайжруулахаас илүү нийлүүлэлтийг бага багаар нэмэгдүүлж, бохир мөнгийг сүлжээндээ оруулдаг.

Жишээ 10

Нөхөн төлбөрийн схем

Бразил, Португалийн иргэд барилгын болон цэвэрлэгээний салбарт Бельги улсад байрших компаниар дамжуулж гэмт хэргээс олсон бэлэн мөнгийг хүлээн авч, нэхэмжлэх гаргаж өгдөг байсан байна. Тус мөнгийг Ази руу илгээж, Бельги худалдаачдын өмнөөс худалдаа хийдэг байсан.



Үйлчилгээнд суурилсан мөнгө угаах

Үйлчилгээнд суурилсан мөнгө угаах (ҮСМУ) нь ХСМУ-аас ялгаатай бөгөөд энэ механизм ашиглагдах эрсдэл нэмэгдсээр байна. ҮСМУ арга нь биет бус хөрөнгө, эд зүйл, үйлчилгээг ашиглан хууль бус бэлэн мөнгийг хууль ёсны болгодог арга юм.

Энэхүү гарын авлагаар ҮСМУ-ыг гүнзгийрүүлэн тайлбарлаагүй болно. Үйлчилгээтэй холбоотой мөн угаах аргын хувьд биед хөрөнгө байхгүй мөн талуудын харилцаа нь хууль ёсны эсэхийг тодорхойлоход хүндрэлтэй байдаг тул илрүүлэхэд хүндрэлтэй байдаг.

Дараах үйлчилгээний салбар нь ҮСМУ-д өртөмтгий байдаг хэмээн тодорхойлогджээ:

- Мөрийтэй тоглоом, онлайн мөрийтэй тоглоом;
- Програмын үйлчилгээ;
- Санхүүгийн аливаа үйлчилгээ;
- Консалтинг болон зөвлөх үйлчилгээ;
- Оюуны өмч, худалдааны тэмдэгтэй холбоотой үйл ажиллагаа.

Хориг арга хэмжээтэй холбоотой эрсдэл

Оросын Холбооны Улс (ОХУ) болон Украйн улсын хооронд 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс үүсээд байгаа нөхцөл байдалтай холбогдуулан дэлхийн улс орнуудаас ОХУ-ын эсрэг хориг арга хэмжээг авч хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд нөхцөл байдлаас хамааран олон улсад гадаад худалдаа болон бусад салбаруудад тавигдах хориг арга хэмжээ цаашид нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, хориг арга хэмжээ авдаг томоохон улс орнууд болон олон улсын байгууллагаас авсан хориг арга хэмжээний тоо 2021-2024 оны хооронд тогтмол өссөн үзүүлэлттэй байна. Жишээлбэл, Европын Холбооноос гаргадаг хориг арга хэмжээний тоо нь 2020 он хүртэлх хугацаанд хамгийн ихдээ 298 (243 хувь хүн, 55 хуулийн этгээд)-д хүрч байсан. Гэтэл 2022 онд хориг арга хэмжээний тоо 1510 (1349 хувь хүн, 161 хуулийн этгээд), 2023 онд 767 (489 хувь хүн, 278 хуулийн этгээд) болж өссөн байна.

Хориг арга хэмжээнээс зайлсхийх, хоригийг тойрч гарах асуудал нь олон улсуудыг хамарсан гадаад худалдаа, хил дамнасан төлбөр тооцоотой холбоо хамааралтай тул худалдаанд суурилсан мөнгө угаах гэмт хэрэгтэй холбогдож болзошгүй тул анхаарч үзэх нь чухал. Тухайлбал, хориг арга хэмжээний цар хүрээ нэмэгдэхийн хэрээр хориг арга хэмжээнд хамаарах улс, этгээдүүд шууд гадаад худалдаа, санхүүгийн харилцаагаа үргэлжлүүлэх боломж хязгаарлагддаг. Энэ нөхцөлд гуравдагч улс, зуучлагч хуулийн этгээд, ре-экспорт, дамжин өнгөрөх худалдаа болон төлбөр тооцооны өөр маршрут ашиглах замаар хоригийг тойрч гарах эрсдэл нэмэгдэх хандлагатай байна. Хоригийг тойрч гарахад дараах нийтлэг арга хэлбэрүүд ажиглагдаж байна. Үүнд:

- гуравдагч улсад шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг импортлогч, экспортлогч, худалдан авагч эсхүл төлбөр төлөгчөөр ашиглах;
- өмнө нь шууд хийгдэж байсан төлбөр тооцоог өөр улс дахь банк, санхүүгийн байгууллага болон зуучлагч компаниар дамжуулах;
- бараа бүтээгдэхүүнийг эцсийн хүрэх улсад шууд нийлүүлэхийн оронд гуравдагч улсад эхлэн нийлүүлж, улмаар ре-экспортлох;
- тээвэрлэлт, дамжин өнгөрөх маршрут, consignee буюу бараа хүлээн авагчийг өөрчлөх;
- барааны эцсийн хэрэглэгч, эцсийн хүрэх газар болон бодит худалдан авагчийг зуучлагч компаниар халхавчлах;
- хориг арга хэмжээ хэрэгжиж эхэлснээс хойш өмнөх худалдааны хэмжээ, давтамж, барааны төрөлтэй ижил төстэй үйл ажиллагааг шинэ компани эсхүл шинэ улсаар дамжуулан үргэлжлүүлэх.

Хориг арга хэмжээний ач холбогдол, үр дагавар

Хориг тавьж буй этгээдийг шинж чанараар нь дараах байдлаар ангилан авч үзэж болно.

- **Олон талт** буюу НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл эсвэл олон улсын засгийн газар хоорондын байгууллагаас (жишээлбэл, Европын Холбоо) тодорхой улс, хуулийн этгээд, хувь хүнд хориг тавьж болно. Тус хориг арга хэмжээг гишүүн улс орнууд нь дагаж мөрдөх үүрэг хүлээнэ. Монгол Улс нь НҮБ-ын гишүүн орны хувьд терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн хориг арга хэмжээний жагсаалтыг заавал дагаж мөрдөх үүрэг хүлээдэг.
- **Нэг талт** буюу нэг улс өөрийн шийдвэрээр нөгөө улс эсвэл улсын иргэн, хуулийн этгээдийн эсрэг хориг тавьж болно. Улс орон бүрд тодорхой улс, хуулийн этгээд, хувь хүнд нэг талын хориг арга хэмжээ хэрэгжүүлэх талаар дотоодын хууль, журам байдаг. Үүний нэг жишээ нь АНУ бөгөөд тус улс нь 1950-иад оноос хойш хориг арга хэмжээ авах бодлогыг гол хэрэгслээ болгон ашиглаж ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд зэрэг 25 улсад хориг тавьсан байна.
- **Хоёрдогч хориг арга хэмжээ** энэ нь хориг арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор хоригт орсон этгээдтэй үйл ажиллагаа явуулж хориг арга хэмжээг тойрон гарахад тусалж буй гуравдагч этгээдийн эсрэг чиглэсэн арга хэмжээ юм.

Санхүүгийн хоригийг тойрч гарах үйл ажиллагаанаас үүдэн улс орнуудын хувь хүн, хуулийн этгээд нь хоёрдогч хориг арга хэмжээнд өртөх эрсдэл нэмэгдэж байна. Хоёрдогч хориг арга хэмжээ нь хориг арга хэмжээнд орсон этгээдийн үйл ажиллагааг хэвийн явагдуулахад туслалцаа үзүүлсэн, хамтран ажилласан гэх санхүүгийн байгууллага, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, хувь хүн, хуулийн этгээдийг хамарч байна. Үүнтэй холбоотой гарсан олон улсын кейсээс дурдвал:

Кейс 1. ОФАК нь БНХАУ-ын Хэбэй Шинхай Химийн Групп ХХК (Hebei Xinhai Chemical Group Co., Ltd.) болон Хятадын Дуньин боомтод (Dongying Port) үйл ажиллагаа явуулдаг гурван компанийг Иран улсын түүхий нефтийг импортолсон гэх шалтгаанаар хориг арга хэмжээний жагсаалтад оруулсан байна.

Кейс 2. Aiotec GmbH компани нь Австралид байрлах полипропилен боловсруулах үйлдвэрийг Иран улсад худалдах үйл ажиллагааг явуулж, эцсийн өмчлөгчийг Турк улсад байгаа хэмээн худал мэдүүлсэн нь тогтоогдсон тул Ираны арилжаа болон хоригийн зохицуулалтын журам (Iranian Transactions and Sanctions Regulations)-ыг зөрчсөн хэрэгт холбогдсон. Үүний улмаас тус компани нь ОФАК-д 14.5 сая ам.долларын торгууль төлөхөөр болсон байна.

Хориг арга хэмжээг тогтоож байгаа субъектээс шалтгаалан түүний эрх зүйн хүчин чадал, хэрэгжүүлэх нөлөөлөл харилцан адилгүй байдаг. Олон талт буюу НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн баталсан хориг арга хэмжээг НҮБ-ын гишүүн орон бүр заавал дагаж мөрдөх шаардлагатай байдаг. Харин нэг талт, эсхүл НҮБ-аас өөр олон улсын засгийн газар хоорондын байгууллагын гаргасан хориг арга хэмжээг бусад улс орнууд олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр заавал дагаж мөрдөх үүрэг хүлээдэггүй бөгөөд зарим орнууд экстерриториаль нэг талт хоригийг олон улсын эрх зүйтэй харшилдаг гэж үздэг. Гэсэн хэдий ч, хоёрдогч хориг арга хэмжээнд орохоос урьдчилан сэргийлэх нь чухал.


Жишээ 12

Хоёрдмол зориулалттай бараа бүтээгдэхүүний эцсийн хэрэглэгч, зориулалт болон хүргэлтийн байршлыг нуун далдлах замаар хориг арга хэмжээнээс зайлсхийх

Хоёрдмол зориулалттай бараа бүтээгдэхүүн: Хориг арга хэмжээний жагсаалтад орсон ОХУ-ын төрийн өндөр албан тушаалтан нь төрийн өмчит “Defense Co” компанийн ТУЗ-ийн гишүүнээр ажилладаг. “Defense Co”-ийн борлуулалтын менежер нь Хонг Конг болон АНЭУ-д хоёр холдинг компани байгуулж, тэдгээрээр дамжуулан Израил улсад бүртгэлтэй “Front Co” компанийг шууд бусаар эзэмшдэг. “Front Co” компани нь АНУ-ын үйлдвэрлэгчээс хоёрдмол зориулалттай (иргэний болон цэргийн зориулалтаар ашиглах боломжтой) бараа бүтээгдэхүүн худалдан авахдаа барааны эцсийн зориулалт, хэрэглэгч болон хүргэх эцсийн байршлын талаар худал мэдүүлж, бараа бүтээгдэхүүн “Front Co” компанид ирсний дараа түүнийг ОХУ дахь “Defense Co” компани руу илгээдэг.

Тансаг хэрэглээний бараа бүтээгдэхүүн: ОХУ-ын нэгэн жижиглэн худалдааны компани 2022 оноос өмнө Европын Холбооны үйлдвэрлэгчдээс тансаг хэрэглээний бараа шууд худалдан авдаг байв. Харин 2022 оноос хойш тус компани Турк улсад зуучлагч (дундын) компани байгуулжээ. Уг компанийг тус жижиглэн худалдааны компани нь АНЭУ болон Кипр улсад бүртгэлтэй хоёр холдинг компаниар дамжуулан эзэмшдэг байна. Турк дахь зуучлагч (дундын) байгууллага нь Европын Холбооны үйлдвэрлэгчдэд тансаг хэрэглээний барааны захиалга өгөхдөө тус бараг ОХУ руу явуулахгүй байх талаар баталгаа гаргадаг. Гэвч бараг хүлээн авсны дараа, Турк дахь зуучлагч (дундын) этгээд нь анхдагч жижиглэн худалдааны компанид буюу ОХУ руу илгээдэг ба тус жижиглэн худалдааны компанийн одоогийн цор ганц эзэмшигч нь хориг арга хэмжээний жагсаалтад багтсан ОХУ-ын төрийн өндөр албан тушаалтны эхнэр байжээ.





Гуравдугаар бүлэг

Худалдаанд суурилсан мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлийн шинж тэмдэг

Худалдаанд суурилсан мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлийн шинж тэмдэг

Эрсдэлийн шинж тэмдгүүдийг практикт хэрхэн ашиглах вэ?

Эрсдэлийн шинж тэмдэг нь хэвийн бус, сэжигтэй үйл ажиллагаатай холбоотой тохиолдлыг урьдчилж таамаглах боломжийг олгодог. Ганц эрсдэлийн шинж тэмдэг нь ХСМУ гэмт хэрэг гэж сэжиглэх хангалттай үндэслэл болохгүй ч нэмэлт хяналт шалгалт хийх хөшүүрэг болно. Харин хэд хэдэн эрсдэлийн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд илүү нарийвчилсан шинжилгээ хийх шаардлагатай болохыг илтгэнэ.

Иймд мэдээлэх үүрэгтэй этгээд болон төрийн эрх бүхий байгууллагууд эдгээр шинж тэмдэг илэрсэн эсэхийг тодорхойлж, хариу арга хэмжээ авч байх нь ХСМУ гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах явцад ихээхэн тус дэм болох юм.

Энэхүү бүлэгт ХСМУ гэмт хэрэг байж болзошгүйг илтгэх эрсдэлийн шинж тэмдгийг
- Байгууллагын бүтэцтэй холбоотой
- Худалдааны үйл ажиллагаатай холбоотой
- Худалдааны баримт бичиг, бараатай холбоотой
- Данс болон гүйлгээтэй холбоотой гэсэн 4 дэд хэсэгт хуваан харуулав.

Байгууллагын бүтэцтэй холбоотой эрсдэлийн шинж тэмдэг

Худалдааны үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага нь:

- Ихэвчлэн логик уялдаа холбоогүй, ойлгоход төвөгтэй бүтэцтэй байх. Жишээлбэл, халхавч компани ашиглах болон өндөр эрсдэлтэй бүс нутагт бүртгэгдсэн зэрэг болно.
- МУТС-тэй тэмцэх тогтолцоо сул бүс нутагт бүртгэлтэй эсвэл салбар оффистой байх
- Хэт ерөнхий эсвэл бизнесийн үйл ажиллагаатай уялдаагүй хаягт бүртгэлтэй байх. Жишээ нь, худалдааны байгууллага нь үйл ажиллагаа эрхлэх тогтсон газар байхгүй, орон сууцанд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд энэ талаар үндэслэлтэй тайлбар өгөхгүй байх
- Цахим хаяггүй эсвэл байгаа цахим хаяг нь тухайн бизнесийн чиглэлтэй нийцэхгүй байх
- Сэжиг төрүүлэхүйц ердийн бус бизнесийн үйл ажиллагаатай байх. Тухайлбал, цалингийн гүйлгээ, үйл ажиллагааны зардал хэт бага, татвар төлдөггүй эсвэл татварын зөрчилтэй байх гэх мэт.
- Байгууллагын захирал болон ахлах удирдлагууд нь эцсийн өмчлөгчийг нуун далдлах зорилгоор томилогдсон байх. Жишээлбэл, тэд гүйлгээний талаар мэдлэг дутмаг эсвэл хэд хэдэн компани удирддаг байх зэрэг болно.
- Захирал, ахлах удирдлагууд өмнө нь гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байсан. Жишээ нь мөнгө угаах схем, залилан, татвартай холбоотой гэмт хэрэг үйлдсэн гэж өмнө нь ял шийтгэл авсан болон энэ талаар шалгагдаж байсан нь нэг эрсдэлийн шинж тэмдэг байж болно.
- Ажилчдын тоо тодорхойгүй, худалдааны үнийн дүн нь тогтмол бус байх
- Томоохон нэр хүндтэй байгууллагын нэртэй ижил төстэй оноосон нэртэй байх
- Тодорхойгүй хугацаанд үйл ажиллагаагаа зогсоосон байх
- НӨАТ-ын тайлан гаргах зэрэг бизнесийн анхан шатны үүргээ биелүүлдэггүй байх

Худалдааны үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийн шинж тэмдэг

- Худалдааны байгууллагын үйл ажиллагаа нь бизнесийн үндсэн чиглэлтэйгээ нийцэхгүй байх
- Бизнесийн үндсэн чиглэлээс гадуур олон зуучлагчтай харилцаж, төвөгтэй хэлцэл хийдэг байх
- Бизнесийн үйл ажиллагааны бодит байдалд үл нийцэх гүйлгээ, тээвэрлэлтийн арга ашигладаг байх
- Санхүүгийн бүтээгдэхүүнийг уламжлалт бус эсвэл хэт нарийн төвөгтэйгөөр ашигладаг байх. Жишээ нь, аккредитивыг тодорхой шалтгаангүйгээр хэт урт эсвэл байнга сунгасан хугацаагаар ашиглах
- Тодорхой шалтгаангүйгээр өөрсдийн ашгийг багаар тайлагнадаг байх. Жишээлбэл. жижиглэнгийн болон түүнээс дээш үнээр бөөний бараа импортлох, эсвэл худалдан авсан үнэтэй нь ижил эсвэл түүнээс доогуур үнээр барааг дахин худалдах
- Бараа бүтээгдэхүүнийг өөрийн дансаар худалдан авдаг боловч худалдан авалтын дүн нь тухайн аж ахуйн нэгжийн эдийн засгийн чадавхаас илт давсан байх. Жишээ нь, байгууллагын данс руу гэнэт их хэмжээний мөнгөн орлого орох эсвэл гуравдагч этгээд худалдан авалтын гүйлгээг санхүүжүүлсэн байх
- Шинээр байгуулагдсан болон дахин үйл ажиллагаагаа эрхэлж буй байгууллага өндөр дүнтэй, томоохон арилжаанд оролцох. Жишээлбэл, зах зээлд нэвтрэхэд төвөгтэй салбарт шинэ орж ирсэн этгээд худалдааны үйл ажиллагаанд оролцох

Худалдааны баримт бичиг, бараатай холбоотой эрсдэлийн шинж тэмдэг

- Гэрээ, нэхэмжлэх болон бусад худалдааны баримт бичгийн үл нийцэл буюу экспортлогч этгээдийн нэр болон төлбөр хүлээн авагчийн нэр хоорондын зөрүү, нэхэмжлэх болон үндсэн гэрээний үнийн зөрүү, эсвэл бодит барааны тоо хэмжээ, чанар, үнэ хоорондоо зөрүүтэй байх
- Гэрээ, нэхэмжлэх болон бусад худалдааны баримт бичгийн үнэ нь зах зээлийн үнэд нийцэхгүй эсвэл харьцуулж болох гүйлгээнээс ихээхэн зөрүүтэй байх.
- Гэрээ, нэхэмжлэх болон бусад худалдааны баримт бичигт барааны талаар тодорхойгүй тайлбар бичсэн байх
- Худалдааны болон гаалийн баримт бичиг дутуу эсвэл төөрөгдүүлсэн болон худал мэдээлэл агуулсан байх. Мөн өмнө нь татгалзсан баримт бичгийг дахин ирүүлэх эсвэл байнга өөрчилдөг байх зэрэг болно.
- Худалдааны гэрээнүүд нь интернэт дэх “жишиг гэрээ”-ний бүтэцтэй ижил байх.
- Бүртгэл дээрх барааны дүн нь гадаад улсын банк руу шилжүүлсэн болон хүлээн авсан төлбөрөөс ихээхэн зөрүүтэй байх
- Түр импортоор тухайн улсад оруулж ирсэн бараа бүтээгдэхүүнийг хуурамч бичиг баримт бүрдүүлэн экспортлох
- Барааны тээвэрлэлтийг эдийн засгийн болон арилжааны үндэслэлгүйгээр хэд хэдэн улс руу шилжүүлэх

Данс болон гүйлгээтэй холбоотой эрсдэлийн шинж тэмдэг

- Худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага барааны төлбөрийн нөхцөлд хожуу өөрчлөлт оруулдаг байх. Жишээлбэл, аж ахуйн нэгж төлбөрийг өөр байгууллага руу шилжүүлэх, эсвэл төлбөр төлөх өдөр төлбөрийн хэмжээг өөрчлөх хүсэлт гаргах гэх мэт.
- Тухайн бизнесийн үйл ажиллагаатай нийцэхгүй хэт өндөр дүнтэй гүйлгээ хийдэг байх.
- Худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын дансны өдрийн эцсийн үлдэгдэл бага бөгөөд тус дансыг “төлбөр төлөх” эсвэл “дамжин өнгөрөх” зорилгоор ашигладаг байх
- Дансанд чөлөөт бүс болон оффшор бүсэд байх бизнесийн хамааралгүй этгээдээс их хэмжээний бэлэн мөнгөөр тогтмол орлого орох
- Данс руу орж ирж буй мөнгөн шилжүүлгийг хувааж, арилжааны үйл ажиллагаатай холбоогүй этгээдийн данс руу шилжүүлэх
- Импортын барааны төлбөрийг эдийн засгийн тодорхой шалтгаангүйгээр бараа хүлээн авагчаас өөр байгууллага хийдэг байх
- Худалдаатай холбоотой мөнгөн орлого болон бусад гүйлгээ нь тайлагнах босго хэмжээнээс үргэлж доогуур байх

Хориг арга хэмжээтэй холбоотой эрсдэлийн шинж тэмдэг

- Хориг арга хэмжээ хэрэгжиж эхэлсний дараа өмнө нь шууд харилцаж байсан гадаад харилцагчийг өөр хуулийн этгээдээр солих.
- Өмнө нь ашиглаж байгаагүй гуравдагч улсын банк, санхүүгийн байгууллагаар төлбөр тооцоо хийх.
- Шинээр байгуулагдсан, эсхүл өмнө нь тухайн бизнесийн харилцаанд оролцож байгаагүй зуучлагч компани гүйлгээний сүлжээнд гэнэт орж ирэх.
- Хориг арга хэмжээ хэрэгжиж эхэлсний дараа өмнөх төлбөр, худалдааны урсгалыг гуравдагч улсын санхүүгийн байгууллага, компаниар дамжуулах.
- Гэрээ, нэхэмжлэх, гааль, тээвэр болон бусад худалдааны баримт бичгийн мэдээлэл хоорондоо зөрөх; барааны нэршил, HS код, үнэ, тоо хэмжээ, чиглэл үндэслэлгүйгээр өөрчлөгдөх
- Хориг, экспортын хяналтад хамаарах барааг өөр ангилалд оруулах, ерөнхий нэршлээр мэдүүлэх
- Харилцагчийн бодит үйл ажиллагаатай нийцэхгүй улс орноос гүйлгээ хийх.
- Өмнө нь ашиглаж байгаагүй улс, санхүүгийн байгууллага, төлбөрийн суваг руу гэнэт шилжих.
- Гүйлгээний IP хаяг нь харилцагчийн бүртгэлтэй улс, бодит үйл ажиллагааны байршилтай нийцэхгүй байх.
- Богино хугацаанд олон улс орноор дамжсан төлбөрийн болон худалдааны урсгал бий болох.



Дөрөвдүгээр бүлэг

Худалдаанд суурилсан мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгарч буй сорилтууд

Худалдаанд суурилсан мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгарч буй сорилтууд

ХСМУ гэмт хэрэгт олон улсын байгууллагууд болон холбогдох салбарын мэргэжилтнүүд ихээхэн анхаарал хандуулж байгаа хэдий ч энэ нь улс орнуудад хүндхэн сорилт хэвээр байна.

ФАТФ-аас 2006, 2008, 2012 онуудад гаргасан гарын авлага болон Дэлхийн Гаалийн Байгууллага, Эгмонт бүлгийн хамтран гаргасан “Гаалийн байгууллага - Санхүүгийн мэдээллийн албаны хамтын ажиллагааны гарын авлага”-д ХСМУ гэмт хэргийг нарийн төвөгтэй мөнгө угаалтын хэлбэр болохыг онцолж, мөрдөн шалгах болон илрүүлэх шатуудад төрөл бүрийн бэрхшээл үүсгэдэг болохыг дурдсан байдаг.

Дараах хэсэгт улс орнууд ХСМУ гэмт хэрэгтэй үр дүнтэйгээр тэмцэхэд тулгарч буй томоохон сорилтуудыг оруулсан болно.

Мэдлэг, ойлголтын дутагдалтай байдал

ФАТФ-аас 2006, 2008 онуудад ХСМУ-тай холбоотой гарын авлага гаргасан нь дэлхийн улс орнуудын анхаарлыг тус асуудал руу чиглүүлж, тэд үүнийг үндэсний эрсдэлийн үнэлгээндээ оруулах болсноор ХСМУ гэмт хэргийн эрсдэлийн талаарх ойлголт нэмэгдэж байна.

Мөн олон улсын байгууллагууд, судлаачид болон улс орнуудын эрх бүхий байгууллагаас ХСМУ гэмт хэргийн чиглэлээр судалгаа, шинжилгээ ихээр хийж буй нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж байна. Гэвч энэ чиглэлээр хийгдсэн судалгаануудад зарим эрх бүхий байгууллагууд ХСМУ гэмт хэргийн талаар анхан шатны ойлголттой байгаа нь гэмт хэргийн нарийн төвөгтэй талыг анзаарахгүй өнгөрөх магадлалтай болохыг дурдсан байна.

Түүнчлэн, эдгээрээс гадна дараах хүчин зүйлс мэдлэг ойлголтын дутагдалтай байдлыг бий болгодог байна.



Эрх бүхий байгууллагууд эдгээр сорилтыг даван туулахын тулд ХСМУ гэмт хэргийн хувьсал, өөрчлөлт, хандлагын талаарх ойлголтоо тасралтгүй шинэчилж байх шаардлагатай.

Мөн цахим худалдааны эрчимтэй өсөлтийн үед эрх бүхий байгууллагууд гэмт хэргийн арга хэлбэрийг тогтоохдоо орчин үеийн худалдааны системийн онцлогийг ойлгон, түүний эсрэг авч хэрэгжүүлэх стратегиа боловсруулах хэрэгтэй юм.


Түүнчлэн, төрийн байгууллагууд сэжигтэй худалдаа, санхүүгийн гүйлгээг цаг алдалгүй илрүүлэхийн тулд өгөгдлийн санг цахим хэлбэрт шилжүүлж, түүн дээрээ тогтмол шинжилгээ хийж байх нь ихээхэн үр дүнтэй.

Дотоод хамтын ажиллагаа болон уялдаа холбоо

ФАТФ-ын зөвлөмжид дотоодын хамтын ажиллагаа болон уялдаа холбоог МУТС-тэй тэмцэх үр дүнтэй системийн суурь хэмээн тодорхойлсон байдаг. Мөн тус зөвлөмжид бодлого боловсруулагчид, хууль сахиулах байгууллага, шүүх хяналтын байгууллага болон бусад холбогдох эрх бүхий байгууллагууд нь хамтран ажиллах, мэдээлэл солилцох үр дүнтэй механизмтай байхыг шаарддаг.


Гэвч дотоодын эрх бүхий байгууллага хоорондын хамтын ажиллагааны дутагдалтай байдал нь өнөө үед анхаарч авч үзэх шаардлагатай томоохон сорилтуудын нэг болж байгаа бөгөөд ХСМУ гэмт хэргийн илрүүлэлт, мөрдөн шалгах ажиллагааг удаашруулж буй гол хүчин зүйл болж байна.

Доорх зурагт ХСМУ гэмт хэрэгтэй тэмцэхэд дотоод хамтын ажиллагааны хүрээнд тулгарч буй сорилтуудыг харуулав.



Олон улсын хамтын ажиллагаа

Олон улсын зохих хамтын ажиллагааг цаг тухай бүрд хэрэгжүүлэх нь олон улс дамнасан гэмт хэргийг үр дүнтэй илрүүлэх, мөрдөн шалгахад нэн чухал юм.



Иймд ХСМУ гэмт хэргийн хувьд, олон улсын хамтын ажиллагааны тусламжтайгаар гэмт хэргийн харьяаллыг үнэн зөв тогтоон түүнийг эцэслэн шалгах боломжтой болдог.

Улс орнуудад бусад улсын байгууллагуудтай үр дүнтэй мэдээлэл солилцох туршлага дутмаг хэвээр байгаа нь ХСМУ гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгалтын явц удаашрах шалтгаан болж байна.

Мөн гадны хамтрагч байгууллагад ирүүлсэн хүсэлтийнх нь дагуу мэдээллээр хангах шаардлага үүсэхэд тухайн мэдээлэл нь өөр өөр эрх бүхий байгууллагад харьяалагддагаас шалтгаалан хүсэлтийн хариу хугацаанаасаа хойшлох тохиолдол гардаг.

Иймд төрийн байгууллагууд нэгдсэн өгөгдлийн сантай болох нь тус асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн ач холбогдолтой.

Мөрдөн шалгах болон шүүх ажиллагаа

ХСМУ гэмт хэргийг яллахад бусад төрлийн мөнгө угаах гэмт хэрэгтэй адилаар угаасан мөнгө, эд хөрөнгө нь хууль бус үйл ажиллагаанаас олсон орлого мөн бөгөөд үүнийг хариуцагч мэдэж байсан гэдгийг нотлох шаардлагатай.

Иймд мөрдөн шалгах болон шүүх ажиллагааг үр дүнтэй явуулахад тулгарч буй сорилтуудыг дор харуулав.



Хувийн хэвшлийн байгууллагуудад тулгарч буй сорилт

ФАТФ-ын зөвлөмжид заасны дагуу хувийн хэвшлийн байгууллагууд МУТС-тэй тэмцэх өргөн хүрээний арга хэмжээг (харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй гүйлгээг мэдээлэх, баримт хадгалах гэх мэт) авч хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг. Эдгээр нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн үйлдлийг хязгаарлах зорилготой бөгөөд санхүүгийн байгууллага болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд МУТС гэмт хэргээс өөрсдийгөө хамгаалах хэрэгсэл болдгоороо ач холбогдолтой.

Гэвч хувийн хэвшлийн байгууллагууд ХСМУ гэмт хэрэгтэй тэмцэхэд дараах түгээмэл сорилтуудтай тулгарч байна.

- **ХСМУ гэмт хэргийн нарийн төвөгтэй байдал:** ХСМУ гэмт хэргийн тасралтгүй хувьсан өөрчлөгдөх чанар болон ямар ч салбар, эд зүйлийг ашиглан үйлдэх боломжтой байдал нь санхүүгийн байгууллагуудад нөөцөө хуваарилах, энэ талаар бизнесийн дүрэм, дагаж мөрдөх тогтолцоондоо нэвтрүүлэхэд хүндрэлтэй болгодог.

- Ихэнх худалдаа, үйлдвэрлэлийн компаниуд мэдээлэх үүрэг хүлээдэггүй тул ХСМУ гэмт этгээдүүд тус салбарыг сонгож гэмт хэрэг үйлдэх нь нэмэгдэж байна.

- **Барааны бодит үнэ цэнийг (БҮЦ) тодорхойлох боломжгүй байдал:** Гэмт хэрэгтнүүд барааг зах зээлийн үнээс нь илүү өндөр эсвэл багаар үнэлж, зөрүү үнэ цэнийг өөр хоорондоо шилжүүлдэг. Харин санхүүгийн байгууллагууд ихэнхдээ худалдаалж буй барааны үнийн талаар тодорхой мэдээлэлгүй байдаг бөгөөд “БҮЦ” -ийг тогтоох нь их хэмжээний нөөц шаардах тул ихэвчлэн нээлттэй эх сурвалжийг ашигладаг байна. Мөн гэмт хэрэгтнүүдийн ашигладаг зарим бараа нь зах зээлд худалдаалагддаггүй тул үүнтэй холбоотойгоор ямар нэгэн жишиг үнэ байхгүй нь ХСМУ гэмт хэргийг илрүүлэхэд хүндрэлтэй болгодог.

- **Тухайн байгууллагын эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл нээлттэй эх сурвалж болон компанийн мэдээлэлд байхгүй байх:** Төлбөр гүйцэтгэгч нь өөр улсын харьяалалд бүртгэлтэй байж болох бөгөөд энэ нь мэдээлэл цуглуулахад ихээхэн хүндрэл учруулдаг.

- **Нээлттэй данс ашиглах:** Энэ нь барааг хүлээн авсны дараа төлбөрийг тодорхой хугацаанд багтаан төлөх боломж олгодог бөгөөд санхүүгийн байгууллагууд тухайн худалдааг хянах боломж хязгаарлагдмал тул гэмт хэрэгтнүүд үүнийг сонгох нь элбэг байдаг.



Тавдугаар бүлэг

Худалдаанд суурилсан мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх сайн туршлага, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Худалдаанд суурилсан мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх сайн туршлага, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

ФАТФ-ын зөвлөмжид МУТС-тэй үр дүнтэйгээр тэмцэхэд авч хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий хүрээг тодорхойлсон бөгөөд энэ нь улс орнуудын хууль, эрх зүйн зохицуулалт болон практикаас хамаарч харилцан адилгүй байж болно гэж заасан байдаг.

Энэ хэсэгт улс орнуудын ХСМУ гэмт хэрэгтэй тэмцэхэд авч хэрэгжүүлсэн сайн туршлагыг хураангуйлан хүргэх болно.

Уншигч та МУТС-тэй тэмцэх талаар нэмэлт мэдээллийг энэхүү гарын авлагаас гадна ФАТФ-ын 2006, 2008, 2012 онуудад гаргасан ХСМУ гэмт хэргийн талаарх судалгааны товхимлуудаас авах боломжтой.

ХСМУ гэмт хэргийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх

Улс орны ХСМУ гэмт хэргийн арга хэлбэрийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх гол стратеги болохыг дээр дурдсан билээ.

Энэ хэсэгт ХСМУ гэмт хэргийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, эрсдэлийг тодорхойлж, үнэлэх тал дээр улс орнуудын авч хэрэгжүүлж буй сайн туршлагыг оруулав.

- Хувийн хэвшлийн байгууллагын ХСМУ гэмт хэргийн тохиолдлыг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Шигтгээ 1. Dutch банкны санаачилга

Нидерланд улсын нэгэн санхүүгийн байгууллага харилцагчдадаа ХСМУ гэмт хэргийн эрсдэлийн талаар ойлголт өгөх зорилгоор гарын авлага гаргажээ. Үүнд ХСМУ гэмт хэргийн бодит жишээ болон тус гэмт хэрэгтэй холбоотой тодруулах зүйлээ асуух боломжтой цахим хаягийг оруулж өгсөн байна.

Эх сурвалж: Нидерланд

- СМА болон эрх бүхий байгууллагууд ХСМУ гэмт хэрэгт өртөх магадлалтай салбаруудын сэжигтэй гүйлгээний тайлангийн чанарыг сайжруулах тал дээр анхаарч ажилласан туршлага

Шигтгээ 2. СМА болон СББМҮҮ хоорондын хамтын ажиллагаа

2019 онд Герман улсын СМА нь Худалдаа аж үйлдвэрийн танхимаар дамжуулан СББМҮҮ болон бусад зохицуулалттай салбаруудад тогтмол лекц, семинар зохион байгуулж, зөвлөмж өгчээ. Үүний үр дүнд СМА-д бүртгүүлэх мэдээлэх үүрэгтэй этгээдийн тоо эрс нэмэгдсэн байна.

Мөн СББМҮҮ нь СМА-ны вэбсайт дээр бүртгүүлсний дараа мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сэжигтэй гүйлгээний тайлан гаргахтай холбоотой болон бусад мэдээллийг авах боломжтой болдог. Харин СМА-д хараахан бүртгүүлээгүй худалдаа эрхлэгчидтэй тэдгээрийн харьяалагддаг холбоодтой нягт харилцаа тогтоож, түүгээрээ дамжуулан мөнгө угаах гэмт хэргийн талаар сургалт орсон байна.

Эх сурвалж: Герман улс

- ХСМУ гэмт хэргийн талаар олон улсын байгууллага болон хувийн хэвшилтэй хамтарч ажилласан туршлага

Шигтгээ 3. ХСМУ гэмт хэргийн тохиолдлуудыг цуглуулсан нь


Эгмонт бүлгийн Мэдээлэл солилцооны ажлын хэсэг 2020 оны 7-р сард “Хилийн чанад дахь их хэмжээний мөнгө угаах гэмт хэргийн хандлага” төслийн үр дүнг нэгтгэн “Case book” гаргасан байна. Энэхүү төсөл нь дэлхийн улс орны СМА-ны туршлагад үндэслэж, ХСМУ гэмт хэргийн холбогдох кейсүүдийг цуглуулан нийтлэг үзүүлэлтүүдийг тодорхойлж, хилийн чанад дахь мөнгө угаах томоохон схемүүдийг таних арга замыг хөгжүүлэхэд чиглэгдсэн.

Кейсүүдийг цуглуулахдаа ХСМУ схем болон ашигласан арга хэлбэрт онцгойлон анхаарал хандуулжээ. Төсөлд нийт 20 гаруй улсын СМА оролцсон бөгөөд үүний үр дүнд олон төрлийн ХСМУ гэмт хэргийн тохиолдлыг багтаасан “Case book”-ыг боловсруулсан байна. Улс орнуудын СМА нь Эгмонт бүлгийн дотоод сүлжээгээрээ дамжуулан “Case book”-тэй танилцах боломжтой. Харин бусад төрийн эрх бүхий байгууллагууд өөрийн улсын СМА-аар дамжуулан тус бүтээлд хандах боломжтой юм.

Эх сурвалж: Эгмонт бүлэг

СМА-ны цуглуулах санхүүгийн мэдээлэл

СМА нь олон төрлийн эх үүсвэрээс мэдээлэл цуглуулж, ХСМУ гэмт хэргийн схемийг илрүүлэх, шинжлэхэд чухал үүрэгтэй оролцдог. Ялангуяа ХСМУ гэмт хэргийг илрүүлэхэд дараах төрлийн мэдээллүүд ихээхэн ач холбогдолтой байдаг.



Эдгээр мэдээллийг цуглуулахдаа бусад орны СМА, дотоодын хууль сахиулах болон гаалийн байгууллагуудтай хоёр талт болон олон талт хэлбэрээр хамтран ажиллах нь ХСМУ-тай тэмцэхэд зайлшгүй шаардлагатай байдаг. Энэ чиглэлээр сайн туршлагад тооцогддог Герман улсын жишээг дор оруулав.

Шигтгээ 4. Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ-ээс бусад салбар сэжигтэй гүйлгээний тайлан мэдээлдэг туршлага

Герман улсын эрх зүйн зохицуулалтад “худалдаа эрхлэгч”-ийг мэдээлэх үүрэгтэй этгээдээр тодорхойлсон байдаг. Иймд СМА нь холбогдох тайланг хүлээн авч сэжигтэй тохиолдлуудыг илрүүлэх боломжтой болсон байна.

Жишээлбэл, нэгэн автомашин үйлдвэрлэгч компанийн дансанд “Х” улсад байрладаг А гэх худалдааны түншийнх нь нэрийн өмнөөс өөр улсад байрлах гуравдагч этгээдээс төлбөр хийгдсэн болохыг СМА-д мэдэгдсэн байна. Ийнхүү СМА үүнтэй ижил шинж бүхий өмнөх жилүүдийн төлбөрүүдийг харахад нийт 50 сая еврог давсан байв.

Үүний дараа өөр нэгэн автомашин үйлдвэрлэгчийн дансанд “Х” улс дахь В гэх худалдааны түншийнх нь нэрийн өмнөөс өөр улсад байрлах гуравдагч этгээдээс төлбөр хийгдсэн болохыг хийгдсэн болохыг илрүүлж, СМА-д мэдээлсэн. СМА-аас шалгаж үзэхэд энэ төрлийн гүйлгээний нийт дүн 30 сая евро давсан байв. Мэдээлэлд дүн шинжилгээ хийсний үр дүнд А, В-ийн эцсийн өмчлөгчид нь нэг хүн болохыг илрүүлсэн байна. Харин тус гүйлгээнд оролцсон гуравдагч этгээдийг судалж үзэхэд тэдгээрийн нэг нь мөнгө угаах гэмт хэргийг зохион байгуулж буй үндсэн компани байжээ.

Эх сурвалж: Герман/Эгмонт бүлэг

СМА-аас ХСМУ гэмт хэргийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх

СМА нь сэжигтэй гүйлгээний тайлан боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэхээс гадна, ХСМУ гэмт хэргийн схемийн талаар илүү нарийн шинжилгээ хийхэд ч гол үүрэгтэй оролцдог. СМА нь олон төрлийн эх сурвалжаас авсан мэдээллийг нэгтгэж, шинжилгээ хийж санхүүгийн схемийн бүрэн зураглалыг гаргадаг. Энэ нь ХСМУ хэргийн илрүүлэлт болон эрсдэлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх зорилготой.

СМА нь ХСМУ гэмт хэрэгтэй холбоотой мэдээлэлд дараах гурван төрлийн дүн шинжилгээг хийж болно.

Үйл ажиллагааны дүн шинжилгээ — Тухайн ХСМУ гэмт хэргийг илрүүлэхэд ашигладаг хамгийн түгээмэл арга (уламжлалт арга) юм.

Стратегийн дүн шинжилгээ — Мэдээлэл хэрэглэгчдэд ХСМУ гэмт хэргийн эрсдэл, арга хандлагын талаар мэдээлэл өгөх зорилготой.

Багц анализ — Технологийн дэвшил, хиймэл оюун ухаан, машин сургалтыг ашиглан ХСМУ гэмт хэргийг илрүүлэх, нарийн төвөгтэй схемийн уялдааг олох зорилготой.

Энэ чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлсэн Итали улсын жишээг дор оруулав.

Шигтгээ 5. Итали улсын СМА-аас хийсэн стратегийн дүн шинжилгээ

Итали улсын СМА нь Төв банкны Статистик шинжилгээний газартай хамтран Итали улсын гадаад худалдааны статистик мэдээлэлд эмпирик шинжилгээ хийжээ. Тус шинжилгээ нь Итали болон түнш улс хоорондын дөрвөн жилийн хугацааны гадаад худалдааны тоон мэдээллийн зөрүүг үнэлэх, улмаар хэвийн бус худалдааны урсгалыг илрүүлж, улс болон салбарын түвшинд ХСМУ эрсдэлийн тоон үзүүлэлтүүдийг тодорхойлох байв.

Үнэлгээний явцад нэг улсаас импортолсон болон экспортолсон барааны үнэлгээг түнш орны гадаад худалдааны барааны үнэлгээтэй тулган баталгаажуулж үзэхэд ихэнх тохиолдолд таарахгүй байсныг илрүүлжээ. Зөрүү үүсгэх гол шалтгааныг даатгал болон ачаа тээврийн зардал, улс орнуудын соёлын ялгаатай байдал, барааны ангилах шалгуурын ялгаа зэрэгтэй холбон тайлбарласан байна.

Энэ хүрээнд Итали улсын СМА үйл ажиллагааны шинжилгээ хийж, бусад эрх бүхий байгууллагуудтай мэдээлэл солилцон ажилласны үр дүнд тэдгээр гадаад худалдааны зарим нь хууль бус байж болохыг илрүүлжээ. Тус шинжилгээг бусад улс орнууд ч мөн адил хийж болох бөгөөд судалгааны холбогдох мэдээллийг НҮБ, Дэлхийн Банк, Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагаас гаргасан эх сурвалжаас цуглуулсан байна.

Эх сурвалж: Итали улс

Эдгээр шинжилгээгээр мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэх боломжтой боловч Санхүүгийн байгууллагууд болон СББМҮҮ нь ХСМУ гэмт хэргийг илрүүлэхэд олон төрлийн сорилттой тулгарсаар байгаа нь сэжигтэй гүйлгээний тайлангийн чанар муу байхад хүргэдэг. Иймд улс орнуудын хувьд Санхүүгийн байгууллагууд болон СББМҮҮ-ийн энэ талын мэдлэг, ур чадварыг сайжруулах арга хэмжээ авах хэрэгтэй.

ХСМУ гэмт хэрэгтэй тэмцэхэд гаалийн байгууллагын үүрэг оролцоо

Гаалийн байгууллага нь худалдааны салбарт олон улсын худалдааны тогтолцоог буруугаар ашиглахтай тэмцэх чиг үүрэг бүхий гол хяналтын байгууллага юм. Тиймээс гаалийн байгууллагууд ОУ-ын худалдааны бүс, барааны урсгал, ОУ-ын нийлүүлэлтийн сүлжээний өргөн хүрээний мэдлэгтэй байх нь ХСМУ гэмт хэргийг илрүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулдаг.

ХСМУ гэмт хэрэгтэй тэмцэхэд гаалийн байгууллага дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

СМА-тай нягт уялдаа холбоотой ажиллах	Дэлхийн гаалийн байгууллага болон Эгмонт бүлгийн хамтран гаргасан “Гааль - СМА хамтын ажиллагааны гарын авлага”-д зөвлөсөн байдаг.
ХСМУ-тай тэмцэх нэгж, хэлтэстэй болох	Гаалийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг болон ХСМУ гэмт хэргийг илрүүлэх үүргийг тусгаарлах зорилготой.
Гаалийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх	ХСМУ гэмт хэргийн схемийг илрүүлэхэд үр дүнтэй арга болдог.

СМА болон Гаалийн байгууллага хооронд үр дүнтэй мэдээлэл солилцох механизм нь МУТС-тэй тэмцэх арга хэмжээний үр ашгийг нэмэгдүүлээд зогсохгүй гаалийн байгууллагын бусад зорилтуудад ихээхэн хувь нэмэр оруулна. Жишээлбэл, өндөр эрсдэлтэй салбарууд болон ХСМУ гэмт хэргийн схемийн талаар мэдээлэлтэй болсноор гаалийн үйлчилгээнд ачаа, тээвэрлэлтийн хяналт шалгалтын тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход тусална.

Мөн гаалийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийх дэвшилтэт арга техникийг нэвтрүүлэх нь худалдаа, залилангийн үйл ажиллагаа болон худалдаатай холбоотой бусад гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлдэг.

Эдгээр арга хэмжээг бодит практик дээр амжилттай хэрэгжүүлж буй олон улсын туршлагуудыг дор харуулав.

Шигтгээ 6. Перу улсын СМА болон Гаалийн байгууллагын хамтын ажиллагаа

Перу улсын СМА нь гаалийн байгууллагын мэргэжилтнүүдэд зориулан дотооддоо дадлагажих боломж олгодог байна. Гаалийн мэргэжилтнүүд СМА-д дадлагажих явцдаа санхүүгийн мэдээлэлд анализ хийх, санхүүгийн шинжилгээний тайлан бэлтгэх чадвараа хөгжүүлдэг. Энэ нь мэргэжилтнүүдийн СМА болон Гаалийн байгууллагуудын уялдаа холбооны талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлдэг.

Эх сурвалж: Перу улсын СМА

Шигтгээ 7. Герман улсын Гааль болон СМА-ны хамтын ажиллагаа

Герман улсын Гаалийн байгууллагын Аудитын алба нь МУТС-тэй тэмцэх чиг үүрэгтэй бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд мэдээлэх хуудас, холбогдох типологийн тайлангуудыг гаргадаг.

Мэдээлэх хуудас нь гадаад худалдааны аудит, гаалийн аудит, санхүүгийн аудит, татварын хяналт шалгалтаар мөнгө угаасныг нотлох баримт илэрсэн тохиолдолд аудитор болон аудитын албаныхан дараагийн авч хэрэгжүүлэх алхмуудыг агуулсан байдаг. Сүүлийн үед тус Аудитын албанаас гоАМЛ программыг ашиглан сэжигтэй гүйлгээг СМА-д шууд илгээдэг болох талаар санал гаргасан байна.

Эх сурвалж: Герман улс

Зохицуулагч байгууллагуудын хамтын ажиллагаа

Эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо нь МУТС гэмт хэргийг таслан зогсоох, амжилттай илрүүлэх гол хүчин зүйл болдог.

Ялангуяа, зохицуулагч байгууллагууд санхүүгийн болон худалдааны бүх мэдээллийг нэгдсэн зураглалд оруулж, хооронд нь харьцуулах механизмыг бий болгох нь ХСМУ гэмт хэргийг илрүүлэх, барааг мөшгөхөд чухал ач холбогдолтой юм.

Энэ чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаж буй улсын туршлагыг дор харуулав.

Шигтгээ 8. Ачаа тээврийн оношилгооны үндэсний төв

2014 онд Израйл улс террорист үйл ажиллагаанд ашиглаж болзошгүй бараанд анхаарал хандуулж, олон улсын худалдааны үйл ажиллагааг хянах зорилгоор “Ачаа тээврийн оношилгооны үндэсний төв”-ийг байгуулсан. Энэхүү төв нь Израйл улсын Татварын ерөнхий газарт байрладаг бөгөөд хууль сахиулах байгууллагын төлөөлөгчдөөс бүрддэг. Мөн терроризмыг санхүүжүүлэхэд ашиглаж болох барааг хууль бусаар хил нэвтрүүлэх худалдааны үйл ажиллагааг илрүүлэх зорилгоор тусгайлсан эрсдэлийн үнэлгээ хийдэг мэдээллийн систем ашигладаг. Хэрэв тус төвд мөнгө угаахтай холбоотой сэжигтэй гүйлгээ илэрсэн тохиолдолд, энэхүү систем нь холбогдох мэдээллийг мөрдөн шалгах нэгжид шилжүүлдэг байна.

Эх сурвалж: Израйл улс

Төр, хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ)

Төр, хувийн хэвшлийн түншлэл нь төрийн байгууллага болон хувийн хэвшлийн байгууллагууд хамтын ажиллагаагаар дамжуулан дундын зорилгодоо хүрэх арга зам болдог.

ФАТФ-ын зөвлөмжид МУТС-тэй тэмцэхэд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг тусгасан боловч түншлэл байгуулахыг шаардаагүй ч улс орнууд дотоодын онцлог нөхцөл, эрсдэлд тулгуурлан ялгаатай арга хэлбэрээр байгуулж байна. Зарим улс орнууд худалдаанд суурилсан мөнгө угаах гэмт хэрэг дээр онцгой анхаарал хандуулж түүнд зориулж түншлэл байгуулдаг бол зарим нь түүнийг мөнгө угаах асуудлын нэг хэсэг хэмээн үзэж нэгдсэн нэг түншлэлийг байгуулдаг.

Аль ч түншлэлийн хэлбэрийг сонгосон улс орнууд нь дараах таван хүчин зүйлийг анхаарч үзэх хэрэгтэй. Үүнд:

- **Түншлэлийн оролцогч талуудыг тодорхойлох:** Түншлэлийн оролцогч талууд нь түншлэлийн зорилгод нийцсэн байх ёстой. Хэрэв ХСМУ гэмт хэргийг тэргүүлэх чиглэлээр тодорхойлсон бол худалдаа, гааль, санхүүгийн чиглэлээр мэргэшсэн хүмүүсийг оруулах хэрэгтэй.
- **Түншлэлийн зорилго болон оролцогч талуудын үүрэг оролцоог тодорхойлох** нь төр, хувийн хэвшлийн байгууллага хооронд найдвартай харилцаа тогтоох үндэс суурь болно.
- **Богино болон урт хугацааны зорилтуудыг тодорхойлох** нь ХСМУ гэмт хэргийн асуудлыг үр дүнтэй шийдвэрлэхэд ихээхэн ач холбогдолтой байдаг.
- **Илүү өргөн хүрээнд мэдээлэл хүргэх:** Түншлэлийн үр дүнг ХСМУ эрсдэлийн талаарх ерөнхий ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор бусад хувийн хэвшлийн байгууллагуудтай хуваалцах нь зүйтэй.
- **Мэдээллийн нууцлалыг хангах:** Үйл ажиллагааны нууцад хамаарах мэдээллийг хамгаалахын тулд мэдээллийн нууцтай холбоотой холбогдох хууль, эрх зүйн актыг дагаж мөрдөх шаардлагатай.

Дараах хэсэгт ХСМУ гэмт хэрэгтэй тэмцэх хүрээнд улс орнуудын төр, хувийн хэвшлийн байгууллага хооронд байгуулсан түншлэлийн жишээг оруулав.

Шигтгээ 9. Финтел Холбооны ХСМУ гэмт хэрэгтэй тэмцэх ажлын хэсэг

Австралийн төр, хувийн хэвшлийн түншлэл болох “Fintel Alliance”-аас ХСМУ гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлд мэдээлэл солилцох, харилцан уялдаа холбоотой ажиллах стратеги боловсруулах зорилгоор тусгайлсан ажлын хэсгийг 2020 онд байгуулсан. Энэхүү ажлын хэсэг нь сар бүр хуралддаг бөгөөд Засгийн газар, хууль сахиулах байгууллага, санхүүгийн салбарын мэргэжилтнүүдээс бүрддэг.

Түүнчлэн, тус ажлын хэсэг нь ХСМУ гэмт хэрэгт санхүүгийн хэрэгслийг хэрхэн ашиглаж буйг тодорхойлж, энэхүү эрсдэлийг бууруулахад чиглэсэн хяналт шалгалтын түвшнийг үнэлэх, мөн ХСМУ-тай тэмцэхэд авч хэрэгжүүлж буй сайн туршлагыг нэвтрүүлэх зорилгоор дотоодын болон олон улсын түншлэлийг өргөжүүлэх тал дээр анхаарч ажилладаг байна.

Тус ажлын хэсэг байгуулагдсаны дараа дараах шинэ санаачилгуудыг гаргасан нь сайн туршлага болсон юм. Үүнд:

- Төрийн болон хувийн хэвшлийн оролцогч талуудын саналд үндэслэн ХСМУ гэмт хэргийн эрсдэлийн үзүүлэлтүүдийг тодорхойлох
- Өндөр эрсдэлтэй салбар дахь сэжигтэй үйл ажиллагааг илрүүлэх, мэдээлэх зорилгоор төрийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааны мэдээлэл солилцох тогтолцоог бий болгох
- Санхүүгийн байгууллагаас худалдааны санхүүжилтийн талаар мэдээлэл олгох тусгайлсан сургалтын хөтөлбөрийг боловсруулж хүргэх

Эх сурвалж: Австрали

Шигтгээ 10. Герман улсын төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа

2019 онд Герман улс Үндэсний эрсдэлийн үнэлгээгээр тодорхойлогдсон эрсдэлд хариу арга хэмжээ авах, МУТС-тэй тэмцэхэд хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор “Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх холбоо” гэх төр, хувийн хэвшлийн түншлэлийг байгуулсан. Энэхүү түншлэл нь Эрүүгийн цагдаагийн газар, Хяналтын байгууллагууд, СМА болон банкны салбарын 14 төлөөлөгчөөс бүрддэг бөгөөд 2019 оны 12 дугаар сарын уулзалтаар ХСМУ гэмт хэрэгт чиглэсэн ажлын хэсэг байгуулахаар болсон байна.

Түүнчлэн, 2019 оны 11 сарын сүүлчээр СМА болон хууль бус худалдааг хянах байгууллагууд Герман улсын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг олон нийтэд үр дүнтэй явуулахын тулд автомашины сэлбэг хэрэгсэл, тээврийн хэрэгслийн холбогдох салбарын хүрээнд анхдугаар “Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх нэгдсэн арга хэмжээ” зохион байгуулсан. СМА нь цаашид энэ төрлийн хамтын ажиллагаа үргэлжлүүлэн явуулахаар төлөвлөж байгаа аж.

Эх сурвалж: Герман

Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба
976-11-326161, 976-11-323434
fiu@mongolbank.mn
https://fiu.mongolbank.mn/